



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 11 өдөр

Дугаар A/320

Улаанбаатар хот

Үнэт цаасны арилжаанд оролцох ажилтны эрхийг түр солих тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.9, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, "Гүүдсек ҮЦК" ХХК-ийн 2025 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 1/71 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гишүүн "Гүүдсек ҮЦК" ХХК-ийн "GDSC.DU" нэртэй Л.Дуламхүүгийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 2025 оны 8 дугаар сарын 11-ний өдрөөс 8 дугаар сарын 27-ны өдрийг дуустал хугацаанд брокер Н.Отгонбямбад түр шилжүүлэн олгосугай.
2. "Гүүдсек ҮЦК" ХХК-ийн брокер Л.Дуламхүүд 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг эргүүлэн олгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх эрх, нууц үг олгохыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДӨЛГӨӨН

1525030863